


Манмин Мэдээ

№ 47 2014 оны 6 сарын 1

Тайзан дээр ундрах Эзэний дуусашгүй агуу хайр нигүүлсэл

“Нулимс” хэмээх сэдэвт Эзэн Дахин амилсаны баярт зориулсан тоглолтын бэлтгэл дээр...



“Хайртай хүмүүстээ үлдээх Миний сэтгэл Бурхан Аавын агуу хайрыг тэдэндээ дамжуулахыг л...”

Энэ бол биднийг аврахын тулд загалмайд цовдлогдсон Есүсийн хүн төрөлхтөн рүү хандсан чин сэтгэлийн хайрын залбирал юм. Манмин Төв Сүмийн урлагийн зөвлөлөөс 2014 оны Дахин амилсаны баярыг “Нулимс” гэсэн сэдвээр бэлтгэсэн билээ.

Энэ тоглолт нь зөвхөн Эзэний төлөө амь амьдралаа зориулсан элч Паул болон Есүсийн бусад шавь нарын амиа зориулж буй үзэгдлээр эхэлж, Есүсийн үйлчлэл, загалмай дээрх цовдлолт, дахин амилалт болон дээшээ хөөрөн одсоныг тайзан дээр дүрслэн үзүүлсэн билээ.

Тоглолтын ерөнхий найруулагыг И Хи жин пастор, удирдсан ба тус тоглолтын дизайнераар МВС урлагын зөвлөлийн дарга, найруулагч Яан Сон дэй ахлагч ажиллав. Хөгжмийн найруулагыг Манмин төв сүмийн урлагын зөвлөлийн зохион байгуулагч И Жин туслагч, Нисси Оркестрагийн удирдаачаар Ким Хангу туслагч гэх мэт эрхмүүд ажилласан юм. Түүнчлэн тоглолтонд урлагийн зөвлөлд багтах багийн гишүүд, болон нэгдсэн Найрал дууны баг, мөн гаднаас ирсэн театрын мэргэжилтэнүүд гэрэлтүүлэг болон тусгай ажлуудыг хийж гүйцэтгэсэн юм.

Энэхүү тоглолтын ерөнхий дизайнераар ажилласан Яан Сон дэй ахлагч “Энэ дахин амилсаны баярын тоглолтыг бэлтгэн гэдэг утгаараа талархал ба сэтгэл хөдлөлөөр дүүрэн байна. Бурхан бидний тоглолтыг илүү сайн хийхэд нөлөөлж, яаж хийвэл бүгдийг сайн илэрхийлэх вэ хэмээн судалж, бүх цаг мөчүүдэд хамт байж сэтгэл гарган бэлдэж буй жүжигчид болон найруулагчийн багийнхан үүний л төлөө бүх зүрх сэтгэлээ гарган ажиллаж байна” гэж хэлж байв. Жил болгоны Дахин амилалтын баяр тохиох Эзэний өдрийн өмнөх баасан гаригийн оройн цуглааны 2-р хэсгээр баярын тоглолтоо үзүүлдэг уламжлалтай бөгөөд уг тоглолтоор итгэгч нарт маш их сэтгэл хөдлөл ба Эзэний хайрыг дамжуулдаг билээ. Ялангуяа 2009 оноос хойш Бурханы өгсөн дуунууд, түүхэн үйл явдлууд үзэгчдийн сэтгэлд маш их таалагдаж, тэдний сэтгэлийг ихээр хөдөлгөж байгаа билээ.

2009 онд “Дурсамж” гэсэн тоглолтоор Есүс цовдлогдохынхоо өмнөх орой Гетсеманд өнгөрүүлсэн өдрүүдийн талаар дурсан санаж дүрслэн үзүүлсэн байдаг.

2010 онд “Эзэний хайр” гэсэн тоглолтоор загалмайд цовдлогдож байгаа Есүсийн төлөө Магдалын Мариагийн гэмшил харуусал мөн Есүсийг гурван удаа үгүйсгэсэн Петрийн гэмшлийг итгэгчид болоод үзэгчдийг зүрхэнд хүртэл дүрслэн үзүүлсэн юм.

2011 онд “Эзэний Зам” гэсэн сэдвээр үзэгчдэд Есүсийн үйлчлэл, цовдлолт, дахин амилалт болоод дээшээ хөөрөн одох үед Түүнтэй хамт байсан тэнгэр элчүүдийн бүжгээр жүжигчилсэн тоглолт хийж үзүүлсэн билээ.

“Хайрын нэр Есүс Христ” гэсэн тоглолтыг 2012 онд элч Паул Есүсийн загалмай дээр сийлэгдсэн хайр болон түүний үйлчлэлийг дурсан санаж буйгаар үзүүлсэн. 2013 онд “Христ бол Эзэн” гэсэн тоглолтоор Магдалын Мариа, Элч Петр, Иохан нар Есүстэй хамт байсан цагаа эргэн дурсаж байгаагаар гардаг. Тоглолт бүр Эзэний хүмүүс рүү хандсан эцэс төгсгөлгүй хайрыг дүрслэн гаргаж үзэгчдэд хүргэж байсан. Сүмийн итгэгчид Эзэний Дахин Амилсан өдрөөр Түүний адил зүрх сэтгэлтэй болохыг хүсэн тэмүүлж итгэлээрээ залбирч Үгийн дагуу амьдарсаар ирсэн билээ.

Энэхүү тоглолт тусгайлан зассан тайзан дээр 2014 оны 4 сарын 18нд Баасан гаригийн оройн цуглааны 2-р хэсгээр тоглосон бөгөөд GCN (www.gcntv.org) гэсэн хаягаар ороод тоглолтыг шууд үзэх бүрэн боломжтой.

Алтнаас ч илүү мэргэн ухаан

“Учир нь мэргэн ухааны ашиг болбоос цалин цагаан мөнгөний ашигаас ч илүү, Орлого нь шижир алтныхаас ч илүү. Энэ нь эрдэнэсээс ч илүү нандин, чиний хүсэх ямар ч зүйл түүнтэй зүйрлэшгүй” (Сургаалт Үгс 3:14-15).



И Жей руг Тэргүүн пастор

Хүн болгоны хувьд өөр өөр зүйлийг эрхэм чухалд тооцдог. Зарим нь нэр хүндийг чухалчилдаг байхад нөгөө хэсэг нь эрх мэдлийг, мэдлэг боловсролыг илүүд үздэг бол өөр нэгэн нь эд баялагийг хамгийн чухал гэж үздэг. Тэгвэл Бурхан айлдахдаа мэргэн ухааныг нандигнадаг хүнийг сайшааж, түүний орлого нь шижир алтнаас ч илүү гэсэн байдаг. Энэ дэлхийн юу ч бидэнд амь ба амар тайвныг өгч чадахгүй ч мэргэн ухааныг хэр зэрэг ашиглаж байгааг шалтгаалж мөнх амийг олоод ч зогсохгүй түүний үнэ цэнийг хэмжихийн ч аргагүй өсгөх ч боломжтой юм.

Мэргэн ухааныг ерөнхийд нь хоёр ангилж болно. Нэг нь амьдралаас сурч туршлагаар олж авдаг ерөнхий мэргэн ухаан бол нөгөө нь дээрээс Бурханаас ирдэг тэнгэрийн мэргэн ухаан юм. Хичнээн ухаантай хүн байсан ч Бурханаас өгөгдөх мэргэн ухааныг гүйцэхгүй боломжгүй юм. Тиймээс ч 1 Коринт 1:25д “Яагаад гэвэл Бурханы мунхаглал нь хүмүүсээс илүү ухаалаг, Бурханы мөхөс байдал нь хүмүүсээс илүү хүчирхэг юм” гэж бичигдсэн байдаг.

1. Бурханаас өгөгддөг мэргэн ухааны шинж чанар

Мэргэн ухаан гэдэг нь олж авсан мэдлэгээ эргүүлэн ашиглахтай адил юм. Хэрэв та ямар ч нөхцөл байдлыг маш сайн ойлгож ухаараад, хамгийн зөв арга замыг олж хардаг байлаа ч танд мэргэн ухаан байхгүй бол ямар ч үнэ цэнэгүй, үр ашиггүй байх болно. Мөн мэргэн ухааныг өөрийн сурч мэдсэн зүйл, туршлагаараа ухаарлыг олж авч болдог ч харин мэргэн ухааныг хүсэн тэмүүлж, бэлэн болсон хүнд л өгөгддөг юм.

Бурханаас өгсөн мэргэн ухааныг олж

авсан хүмүүс зүрх сэтгэлээ хэрхэн яаж өөрчлөхийг мэддэг. Тэд аливаа зүйлийг яг л усны урсгал шиг болгон, эв нэгдлийг бий болгож чаддаг. Харин эсрэгээр хичнээн сайн ажил үйлс хийж байлаа ч мэргэн ухаанаар дутмаг хүмүүс эв нэгдэл хагалж сөрөг бодол, үйлдэл гаргадаг.

Энэ мэтчилэн ухаалаг хүмүүс зөвхөн ганцхан үгээр ивээл ерөөл, хайрыг хүлээж авдаг бол мэргэн ухаанаар дутмаг, ухаан муутай хүмүүс тэдэнд байгаа боломжоо алдаж, үг хэлээрээ өөрсдийгөө хүнд хэцүү байдалд оруулах болно. Хэрэв бид мэргэн ухаангүй байвал бидний нөр их хөдөлмөр, хичээл зүтгэлийн үр дүн муу байх болно. Харин мэргэн ухааныг авсан хүмүүс Бурханаас гуйж маш олон арга замаар асуудлыг шийдвэрлэж чаддаг учраас илүү сайн үр дүнд хүрдэг юм.

Тэд үргэлж залбирч Бурханаас гуйж байдаг тул Бурханы ивээл, нигүүлслийг алддаггүй харин ч сайхан боломжуудыг үргэлж бий болгож чаддаг юм. Хэрэв бидэнд Бурханы өгсөн мэргэн ухаан байвал залбирлынхаа хариултыг илүү дөт замаар авч, үр жимс, ивээл ерөөлийг эдлэх болно.

2. Бурханаас мэргэн ухааны ивээлийг авсан Соломон хаан

Мэргэн ухааны талаар ярихдаа Соломон хааны тухай дурдахгүй байх боломжгүй юм. Учир нь Давидаас хаан ширээг өвлөн авч Бурханд чин сэтгэлээсээ 1000 шагаалт тахил өргөж, энэ нь жинхэнэ ариун, анхилуун үнэрт тахил болж чадсан билээ. Хуучин гэрээний үед энэ нь хамгийн энгийн арга байсан бөгөөд өнөө үед бол бүх Эзэний өдрийн мөргөл болон Дахин амилалтын баярын цуглаан, Ургац хураалтын талархалын цуглаан гэх мэт онцгой талархалын мөргөлүүдтэй ижил утгыг илэрхийлдэг юм.

Соломон хаан хэрхэн чин сэтгэлээсээ тахил өргөсөн учраас Бурхан зүүдэнд нь үзэгдэж “Чи Надаас юу авахыг хүсэж байна вэ? Түүнийгээ Надаас гуйгтун” (Шастирын дэд 1:7) гэж айлдсан байдаг. Соломон нэр алдар, тансаг амьдрал гуйгаагүй харин ард түмнээ сайн захирч удирдах мэргэн ухааныг гуйсан байдаг. Өөрийн алдар нэр, ашиг сонирхолын төлөө биш ард түмнээ гэсэн сайхан сэтгэлийг нь хараад Бурхан ч бас баярлаж түүнд эд хөрөнгө, эрх мэдэл, алдар нэрийг хүртэл ивээл болгон өгсөн. (Шастирын дэд 1:11-12).

Бурханаас ийм агуу мэргэн ухааныг

авсан Соломоны тухай Шебагийн хаган хаан сонсоод үнэн эсэхийг өөрийн нүдээр ирж үзэхийг хүсэн түүнд маш их хэмжээний өргөл барьц авч ирдэг. Тэр хаган хаан “би ирж энэ бүхнийг өөрийн нүдээр үзэх хүртлээ итгээгүй байлаа. Гэтэл миний сонссон зүйлс энэ бүгдийн хагас нь л байж. Үнэндээ таны мэргэн ухаан, хөгжил цэцэглэлт миний сонсож дуулснаас үлэмж их ажээ” (Хаадын Дээд 10:7) гэж хэлсэн байдаг.

Хаадын Дээд 3-р бүлэгт Соломоныг ямар агуу мэргэн ухаантай шүүгч болохыг дурдсан байна. Нэгэн өдөр хоёр эмэгтэй нэг хүүхдийг Соломон хааны өмнө авчиргаад хоёулаа түүний ээж нь мөн гэж хэрэлдэж гэнэ.

Тэр хоёр хоёулаа гуравхан өдрийн зөрөөтэй хүүхэд төрүүлсэн боловч нэг эмэгтэй нь өөрийн буруугаас болж шөнө хүүхдээ няц дарж алчихаад нөгөө эмэгтэйнхээ амьд байгаа хүүхдээр солиод өвөрт нь хийчихдэг. Өглөө болоход нөгөө эмэгтэй өвөрт нь байгаа үхсэн хүүхэд өөрийнх нь биш байсаныг мэдээд эцэст Соломон хааны өмнө хоёулаа зарга мэдүүлэхээр ирсэн. Соломон хаан “сэлэм аваад ир” гэхэд хүмүүс хааны өмнө сэлэм авчрав. “Амьд байгаа хүүг хоёр хувааж талыг нь нэг эмэгтэй, нөгөө талыг нь нөгөө эмэгтэйд өг” гэж тушаав.

Тэгтэл амьд байгаа хүүгийн эх нь хүүгээ маш их өрөвдөж, хүүгээ амь үлдээгээд нөгөө эмэгтэйд өгөхийг гуйв. Гэтэл нөгөө эмэгтэй нь хааны шийдвэрт баяртай байсаныг хараад амьд үлдээхийг хүсэж байгаа нь хүүхдийн ээж мөн гээд түүнд хүүг өгсөн байна. Өөрийнхөө амь, амьдралаасаа ч илүү хүүгээ хайрласан ээж хүний хайрыг Соломон хаан сайн ойлгосон байна.

Энэ мэт мэргэн ухаантай хүн нь ээдрээтэй хүнд асуудлыг тайлж өгөн, зөв шударга шүүн тунгааж эргэн тойронд хүмүүс ч ухаантай хүн гэж хүндэтгэх болно.

3. Ухаалаг эмэгтэй Абигал

1 Самуел 25-р бүлэгт гардаг Абигал гэдэг эмэгтэй маш аюултай, үхэж ч болзошгүй нөхцөл байдлыг маш ухаалагаар эргүүлж Бурханаас ивээл ерөөл авч чадсан тухай гардаг. Энэ нь Давид Саул хааны илднээс зугтаж тэнүүлэн байх үед болсон явдал юм.

Урьд Давид болон түүний нөхөд нь Саулаас зугтаж байхдаа өлсөж ядрах үедээ хоньчдод нь туслаж байсан тэр тусыг санаж туслах болов уу гэж бодоод баян эр Набал руу хүнс хоол залгуулаач гэж хүн илгээжээ. Тэр үед Давид өөрийгөө Набалын өмнө

даруухнаар тусламж гуйсанд Набал түүнийг дорд үзэж, бүр доромжилсон үгээр хариу барьсанд Давидын уур хүрч тэднийхнийг 400 цэрэг бэлтгэн дайлаар мордохоор болов.

Энэ мэдээ тэр даруй Набалын эхнэр Абигалд хүрч тэр маш яаралтай талх, дарс, хэрэгтэй бүх зүйлсийг илжгэн дээр ачаад Давидтай уулзахаар даруй хөдлөв. Давидын хүмүүст хоол хүнс маш их хэрэгтэй байсан учраас тэр хэрэгтэй зүйлсийг нь бэлтгэж өгсөн байна.

Эндээс бид Абигалын ухаалаг зан чанарын талаар сурч болно. Абигал Давидтай уулзахдаа түүний өмнө мөргөж нөхрийнхөө өмнөөс дарууханаар уучлалт гуйдаг. Мөн тэр маш эелдэг болгоомжтойгоор хэрэв Давид Набалын хүмүүсийн цусыг урсгавал Бурхан дуртай байхгүй байх болно гэдгийг сануулан хэлсэн байдаг.

Давид Абигалд “Өнөөдөр чамайг надтай уулзуулахаар явуулсан Израйлийн Бурхан ЭЗЭН магтагдах болтугай. Мөн чиний саруул ухаан магтагдах болтугай. Намайг өнөөдөр цус урсгахаас болон өөрийнхөө гараар өөрийн өшөөг авахаас болиулсан чи магтагдах болтугай” (1 Самуел 25:32-33) гэж хэлсэн.

Ингэж Абигал Давидын сэтгэлийг тайтгаруулаад гэртээ ирэхэд Набал хаан хүн шиг найр хийж ихэд согтуу байсан тул маргааш өглөө болтол тэр нөхөртөө юу ч ярьсангүй. Тэр өдөр юу болсоныг согтуу хүнд хэлвэл юу ч болж магадгүй гэдгийг мэдэж байсан учраас юм. Тиймээс мэргэн ухаантай Абигал өглөө нь нөхрийнхөө согтууг гарахаар нь болсон бүх зүйлсийг ярьсанд нөхөр нь айж, бие нь чулуу шиг хөшсөн байлаа. Тэгээд арван өдрийн дараа тэр нас баржээ.

Энэ мэт Абигалын ухаалаг үйлдлээр өөрөө болон бүх гэр бүл нь аюулаас аврагдав. Үүнээс харахад бидний ухаалаг эсвэл мунхаг байдлаас шалтгаалаад аливаа зүйл сайнаар эргэж, амар хялбар болох эсвэл өчүүхэн жаахан шалихгүй юмнаас асуудал бүр хүндэрч хэцүү ч болж болох юм.

Хайрт итгэлийн ахан дүүс минь, Иаков 3:17 “Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж” гэсэн байдаг билээ. Дээрээс ирэх мэргэн ухааныг эзэмшиж, Бурханы хүүхэд болох ерөөлийг хүссэн хэмжээгээр эдлэхийг Эзэний нэрээр хүсэн ерөөе!

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org



Сайн мууг мэдүүлэгч жимсэнд агуулагдсан Бурханы хүсэл ба хайр

Анхны хүн Адам, Ева хоёр идэхийг хориглосон сайн мууг мэдүүлэгч модны жимсийг идсэнээр сүйрлийн замаар явсан тухай сонссон билээ. Бүхнийг мэдэгч, төгс хүчит Бурхан хожим энэ жимсийг иднэ гэдгийг урьдаас мэдэж байсан байх. Тэгвэл яагаад сайн мууг мэдүүлэгч жимсийг байрлуулах болсон юм бол?

Ихэнх хүмүүс “Адам, Ева хоёрыг үхэл рүү аваачих тэр сайн мууг мэдүүлэгч модыг Бурхан яагаад бүтээсэн юм бэ?” гэж асуудаг. Тэр ч байтугай Адамыг тэр жимснээс иднэ гэдгийг Бурхан мэдээгүй байж магадгүй гэж ярьдаг. Үнэхээр тийм гэж үү! Огтхон ч тийм биш юм.

Бурхан Адам энэ жимснээс идэж гэмтэн болно гэдгийг анхнаасаа мэдэж байсан. Тийм ч учраас Тэрээр бүх зүйлийг бүтээхээсээ ч өмнө аль хэдийн хүн төрлөхтөнийг аврах арга замыг бэлдчихсэн байсан юм. Бурхан энэ үеийн хэнд л Есүс Христийг бэлдчихсэн байсан.

Тэгвэл сайн мууг мэдүүлэгч жимсэнд агуулагдаж байгаа Бурханы хүсэл болон хайрын тухай нарийвчлан судлаж үзэцгээе.

Анхны хүн Адам, Ева хоёр өөрсдийн чөлөөт сонголтоор сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идсэний үр дүн

Анхны хүн Адам нь зах хязгааргүй агуу уудам Еден цэцэрлэгт Бурханы тухай, сүнслэг ертөнцийн тухай, жинхэнэ үнэн, ба сайхан сэтгэл, гэрлийн тухай маш олон сүнслэг мэдлэгийг суралцаж, мөн бүх зүйлийг захирах хангалттай мэдлэгүүд болон байсан бөгөөд бүх амьтад, хийгээд бүх бүтээлийг удирдан захирах эрх мэдлийг хүлээн авсан юм. Мөн маш олон үр хүүхэдтэй болж өсөж үржиж, өнөр өтгөн болцгоосон юм (Эхлэл 1:28, 2:19, 3:16). Тэдэнд Бурхан зөвхөн ганцхан зүйлийг л хориглосон тэр нь цэцэрлэгийн төвд орших сайн мууг мэдүүлэх модны жимснээс л идэж болохгүй гэв.

Эхлэл 2:16-17д үзвэл “Тэгээд ЭЗЭН Бурхан тэр хүнд тушаан ийнхүү өгүүлэв. Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг дураараа идэж болно. Харин чи сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ! хэмээн айлдав” гэсэн байдаг. Бурхан анхны хүн Адамыг бүтээгээд түүнд өөрөө хийх, шийдвэр гаргах, сонгох эрх чөлөөг өгсөн. Тэр түүнийг Еден цэцэрлэгт үүрд мөнх амьдрахыг зөвшөөрсөн. Гэвч Адамыг газар шороогоор бүтээгдэж, Бурханы амин амьсгалаар тэрээр амьд оршигч болсон ба хэрвээ Адам дуулгаваргүй байдал гаргавал мөнхөд амьдрах боломжгүй болохыг байнга сануулахын тулд Еден цэцэрлэгийн төв хэсэгт сайн мууг мэдүүлэгч модыг бүтээж анхааруулж байсныг харж болно.

Тэгээд Адам, Ева хоёр асар олон жил бидний төсөөлшгүй урт удаан хугацааны турш Бурханы үгэнд дуулгавартай байж тэр модны жимснээс идээгүй байсан юм. Гэсэн ч цаг хугацаа өнгөрч эцэст нь тэдний зүрх сэтгэлд байсан Бурханы тушаалыг сахиж чадаагүй юм. Еватай хамгийн ойр дотно байсан могой Еваг уруу татаж, сайн дураараа өөрөө сонголтоо хийж жимснээс идээд мөн Адамд ч бас өгсөнд Адам ч бас түүнээс нь аваад идсэн юм. Ингээд л тэд эцсийн эцэст Бурханы зайлшгүй үхэл болно гэж айлдсаны дагуу “Нүглийн хөлс бол үхэл” (Ром 6:23) гэсэн сүнслэг хуулийн дагуу гэм нүглийнхээ хөлсийг төлөх шаардлагатай болсон.

Бурхан “Зайлшгүй үхэл болно” гэсэн нь хүний бие, сэтгэл, сүнсийг удирдаж байдаг сүнсний үхлийг хэлж байгаа юм. Сүнс үхнэ гэдэг нь сүнс нь тэр чигтээ устаж үгүй болно гэсэн үг биш, харин Бурхантай холбоо тасарч, сүнсний үйл ажиллагаа нь үхмэл зогсонги болохыг хэлж байгаа юм. Ингэж хүний сүнс үхмэл, зогсонги болвол махан бие нь ч үхэж мөхөх болдог.

Гэтэл Адам гэм нүглээс болоод зөвхөн өөрөө л хараал хүртэх бус түүний хойч үе, үр удам хүртэл гэмтэн болж нүгэлд унах болсон. Мөн Адамын захирч байсан бүх амьтан, ургамал, газар хараагдаж, хүнд хүчир ажил хийж хоолоо олж идэх болсон (Эхлэл 3:17). Хараагдсан газар дээр урьд өмнө байгаагүй өвчин гарч, хүмүүс Сатанаар соригдож, зовж зүдрэх болсон. Могой бүх амьтанаас илүү их хараагдаж, үргэлж хэвлийгээрээ мөлхөх болсон (Эхлэл 3:14).

Эсрэг талыг мэдрүүлж өгөн, бидэнд жинхэнэ аз жаргалыг өгөх гэсэн Бурханы хайр

Тэгвэл, Бурхан яагаад сайн мууг мэдүүлэгч модыг Еден цэцэрлэгийн голд байрлуулсан юм бол? Шууд хэлэхэд бидэнд жинхэнэ аз жаргалыг өгөхийн тулд юм. Бид Адам, Ева хоёрыг маш үзэсгэлэнтэй Еден цэцэрлэгт, амар тайван, дутагдаж гачигдах зүйлгүй сайхан амьдарч байсан гэж төсөөлдөг ч тэд үнэндээ жинхэнэ аз жаргал гэгчийг ердөө ч мэдрээгүй байна. Яагаад гэвэл тэд уйтгар гуниг гэдгийг мэдэхгүй учраас тэр юм. Тэдэнд ямар ч өвчин зовлон, үхэл хагацал, осол авар, бэртэл гэмтэл, уй гашуу байгаагүй, юу байдгийг нь ч мэдэхгүй, мэдрэхгүй амьдарч байсан учраас тэр шүү дээ. Тэнд үхэл гэж байгаагүй учраас үхэл, хагацал гэж чухам яг юу болохыг тэд мэддэггүй байсан болохоор юм. Хүмүүс ямар нэгэн зүйлийн үнэ цэнийг түүний эсрэг зүйлийг үзэж, амсаж байж л сая ойлгодог. Жишээ нь хамгийн наад зах нь бидэнд маш хэцүү хүнд асуудал, зовлон бэрхшээл тулгарвал жинхэнэ аз жаргал гэгч юу болохыг тэр үед л их сайн ойлгодог. Өвчин зовлон, шаналал дотроос бид эрүүл саруул байхын чухалыг үнэн голоосоо ухаарч, эрүүл саруул байгаадаа талархаж байдаг. Өлсөж үзсэн хүн өлсгөлөн хүний зовлонг ойлгож, идэх хоолтой байгаадаа баярладаг биз дээ. Хорон муутай учирсан хүн сайн сайханыг мэдрэж, харанхуйгаар явсан хүн гэрлийн сайханыг мэдрдэг. Ядуу байж үзээгүй хүн баян байгаадаа талархаж чадахгүй, үзэн ядалтыг мэдрээгүй хүн хайр ямар агуу болохыг ч бас мэдрэхгүй. Адам Еден цэцэрлэгт баяр баясгалан, аз жаргалын үнэ цэнийг ойлгох чадваргүй амьдарч байсан. Яагаад гэвэл тэр үхэл гэдгийг хэзээ ч үзээгүй учраас Бурханы айлдсан “энэ жимсийг идсэн даруйдаа зайлшгүй үхэх болно” гэсэн үгний утга учрыг нь ойлгоогүй байсан. Бурхан Адамд үнэхээр их хайртай байсан тул түүний бүх зүйлээр хангаж байсан ч түүний зүрх сэтгэлээс чин сэтгэлийн баяр, талархал гардаггүй байжээ. Харин Адам гэм нүгэл үйлдэж Еденээс хөөгдсөнийхөө дараа өлсөж, цангаж, ядарч, даарч, үхэл хагацал үзэж, зовж шаналж маш олон зовлон зүдүүрийг амсаж байж сая л Еден цэцэрлэгт ямар их аз жаргалтай байсан гэдгээ ойлгож ухаардаг. Ингэж эсрэг зүйлийг нь мэдрэхгүйгээр аливаа юмны жинхэнэ үнэ цэнийг мэдрдэггүй байна. Тиймээс Бурхан бидэнд үнэнийг ойлгуулахын тулд, жинхэнэ аз жаргалтай байлгахын тулд Еден цэцэрлэгийн голд сайн мууг мэдүүлэх модыг байрлуулсан байна.

Бид ч гэсэн газар шорооноос бий болсон Адамын үр удамын хувьд энэ газар дээр хүн төрөлхтөнийг дасгалжуулах үйл явцыг туулж өнгөрөөж байж л тэнгэрийн орны амьдрал ямар сайхан болохыг ойлгож, мэдрч чадах болно. Тиймээс ямар ч гэм нүгэлгүй, уй гашуу байхгүй Тэнгэрийн орон ямар гайхамшигтай сайхан болохыг чин сэтгэлээсээ мэдрч байгаа болохоор ийм сайхан Тэнгэрийн орныг бидэнд өгсөн Бурханд мөнхөөс мөнхөд талархаж амьдрах болно. Тиймээс Есүс Христийг хүлээн авсан хүн бүр жинхэнэ итгэлээр амьдарч, Тэнгэрийн орны баяр, талархалд найдаж, энэ дэлхийн амьдрал ямар ч байсан баяртай байдаг билээ (2 Коринт 4:17-18). Бидний гэм нүглийн хэцүү асуудлыг шийдэж өгсөн Эзэний хайрыг чин сэтгэлээсээ ухаарч, ойлгож, мэдрэх үед Тэнгэрийн орны итгэл найдвар дотор жинхэнэ аз жаргалтай байж чаддаг юм.

“Цээжний хөндийд хий хурах, болон уушгины архаг өвчнөөсөө эдгэрч хүссэнээрээ Бурханыг магтдаг болсон!”

2003 онд миний баруун хавирга хугарч, уушиг маань гэмтсэн байсан учраас цээжиндээ гуурсан хоолойтой байлаа. Жаахан ханиад хүрэх юм уу бронхит хөдлөх үед эмнэлэг рүү л явдаг байв. Энэ үед зөвхөн махан бие минь өвдөөд зогсохгүй сүнсний хувьд яг л хатсан газар шиг маш их ангаж цангаж, сэтгэлээр их унадаг байсан тул алдартай пасторуудын олон ч ном уншиж, их ч залбирдаг байлаа. Гэвч түрхэн зуур сэтгэл минь жаахан өөдрөг эерэг хандлагатай болж байсан ч сүнсний маань цангаа ердөө ч тайлагддаггүй байсан.

2010 оны 1-р сард би И Жей руг Пасторын *Сүнс сэтгэл ба махан бие* гэдэг номыг хадам эгч И Сон уг туслалцаас авч уншсан. Энэ номонд Шинэ Иерусалимын (Илчлэлт 21:2) тухай, хүн төрөлхтөнийг боловсруулах Бурханы төлөвлөгөө, Төгс Сүнс (1 Тесалоник 5:23) гэх мэт миний урьд өмнө хэзээ ч сонсож байгаагүй зүйлийн тухай бичсэн байсан. Энэ бүхнийг уншаад үнэхээр их гайхаж байсан шүү. 2010 оны 1 сард Манмин Төв сүмд бүртгэгдэж, итгэлийн амьдралаа дахин шинээр эхэлсэн.

Би сүмийнхээ урлагын зөвлөлийн гоцлол дуучин болсон ч хамгийн хэцүү асуудал бол онцгой дуу бэлдэж байхад ханиад хүрч эсвэл амьсгалын замын үрэвсэл маань хүндэрч хоолой сайн гарч өгдөггүй болохоор би эмэнд л найдаж хэрэглэдэг байсан. Энэ байдал олон удаа давтагдах тоолондоо Бурханыг мэдэлт хүч илрэн гардаг сүмд явдаг мөртлөө итгэлээ харуулж чадахгүй байгаадаа би өөрөөсөө ичдэг байв.

2013 оны 11 сарын бнд онцгой дуу бэлдэж байх үед ханиад хүрч цэртэй ханиагаад биеийн байдал улам бүр муудаж байлаа. Гэтэл яг онцгой дуу өргөх тэр өдөр цустай ханиаж, цээжээр яг л сэлмээр хатгаж байгаа юм шиг өвдөж, цэх зогсож ч чадахгүй бөхийгөөд нэг буланд зогсож байсан. Гэсэн ч би эмнэлэг рүү яваагүй. Учир нь би итгэлээрээ эдгэрнэ гэсэн шийдвэрийг гаргачихсан байсан. Тэгээд Манмин залбирлын төвийн ахлагч И Буг ним болон И Хи жин пастораас залбирал авсан. Тэр өдөр би ямар ч асуудалгүй онцгой дуугаа өргөж чадсан юм.




И Сон ү Туслалцагч (49 настай, 1-2 тойрог Өмнөд Солонгос)

Би итгэлээрээ бүрэн эдгэрэхийн тулд эмнэлэгт дахин нарийн шинжилгээ хийлгэсэнд цээжний рентген зурганд миний баруун уушиг хэвийн биш, цээжинд хий хуралдсан ужиг өвчтэй болохыг мэдсэн (цээжинд их хэмжээний агаар, хий хуралдсан, цээжний хөндий болон уушиг их хүндэрсэн учир хэвийн амьсгалж чадахгүй). Үүний дараа Тэргүүн Пасторыг уулын залбирлаас эргэн ирэх хүртэл өөрийгөө эргэн харж, өөрт байгаа алдаа дутагдал, бүх л гэм буруугаа бүгдийн чин сэтгэлээсээ гэмшин залбирал хийсэн юм.

Би онцгой дууг дуулж байхдаа итгэгчдэд хүлээн зөвшөөрөгдөхийг хүсэж сэтгэл, өөрийгөө ил гаргах, олны анхаарлын төвд орох гэх мэт зүйлүүдээ чин сэтгэлээсээ гэмшин залбирч байлаа. Тэгээд эдгэрлийн залбирал авахад өөрийгөө бэлдэж, 2013 оны 12 сарын 29нд өвчин эдгээх залбирлыг чин сэтгэлээсээ хүсэн тэмүүлж авсан. Тэр дороо ханиаж байсанаа зогсож, цэр багасаж эхэлсэн. Маргааш нь гэхэд бүр юу ч үгүй цэвэрхэн эдгэрсэн билээ. Би ямар их баярласан гээч!

2014 оны 1 сарын 15нд эдгэрсэнийхээ дараа баталгаажуулахаар дахин шинжилгээ өгсөн. Эмч маань “Цээжний хий хуралт байхгүй болсон байна. Та одоо эв эрүүл, цэвэр уушигтай болжээ” гэсэн баярт мэдээг хэлсэн. Халлелуяа!

Уушгины архаг үрэвсэл өвчнөөс минь эдгээж өгч, эрүүл биеэр хүссэнээрээ магтаал өргөхийн тулд ерөөж өгсөн Бурхан Аавдаа бүх алдар талархалыг өргөө.



Залбирлын өмнө (2013 оны 12 сарын 9) баруун уушгинд хий хуралдсан байдал (шар сум)
Залбирлын дараа (2014 оны 1 сарын 15): хуралдсан хий байхгүй, хэвийн уушиг

Ражендра Прасад
Бист итгэгч (Малайзи)

“Сургаал хадгалсан миний гар утсанд гайхамшигтай зүйл тохиолдсон нь”



Би Непалд Хиндү шашинтай гэр бүлд төрж өссөн ч Бурханы ивээлээр Эзэнийг хүлээн авч аз жаргалтай амьдралаар амьдарч байна.

2013 оны 9-р сард Малайзийн виз авахаар Непалийн Катманду хот руу явсан. Тэнд Муна Бата гэдэг эгчийндээ сар орчим амьдарч байлаа. Тэр эгч маань Непаль Манмин Сайн мэдээний төв (Хариуцагч И Хэ чон пастор) д үйлчилдэг юм. Эгч маань Манмин Төв сүмийн И Жей руг тэргүүн пасторын тухай, мөн хэрхэн Бурхантай уулзаж долоон жилийн турш хүнд өвчний улмаас зовж байсан, яаж өвчнөөсөө эдгэрсэн тухай ярьж өгдөг байлаа. Үүнийг сонсоод “Бурхан жинхэнээсээ амьд байхнээ” гэсэн бодол орж ирэн,

би Непалын Манмин сүмд явж эхэлсэн. Би тэнд сургаал сонсож, библи уншиж, залбирдаг байлаа.

Малайзруу явахаасаа өмнө Тэргүүн Пасторын 80 гаруй сургаалыг гар утсандаа хадгалсан байв. Эхний долоо хоногт өдөр бүр дор хаяж таван сургаал сонсож, 1 цагаас илүү залбирдаг байлаа. Тэгээд “Него” супермаркетад ажиллах ерөөл аваад, талархан аравны нэгээ баяртай зүрх сэтгэлээр өргөж эхэллээ.

Сар орчмын дараа би гайхамшигтай зүйлтэй учирсан. Миний утсан дээр Есүс загалмайд цовдогдож байгаа дүр зураг хоёр ч удаа гарсан. Энэ дүр зурагтай хамт таван минут орчим нэгэн залбирал сонсогдож байгаад дараа нь магтан дуугаар солигдсон

юм. Дараа нь би тэр залбирлыг И Жей руг пасторын өвчин эдгээх залбирал болохыг олж мэдсэн юм. Гол учир нь миний гар утсанд Есүсийн цовдлогдож байгаа зураг байхгүй тул маш их гайхаж байлаа.

Энэ бүхнийг миний утсанд үзүүлж, Бурханы хайрыг надад ухааруулж өгсөнд үнэхээр их талархах сэтгэл төрсөн. Би утсандаа хадгалсан сургаалуудаа үргэлжлүүлэн сонсож, Бурханы хайрыг Эзэний хайрыг ухаарч ивээл авч байна. Мөн Тэргүүн Пастор зөвхөн сайныг л үйлд, бусдын эрх ашгийг харж, тэдний сайн сайхны төлөө байх хэрэгтэй гэж сургасан тул би хичээн зүтгэж байгаа бөгөөд түүний үр дүнд цалин ч нэмэгдэж ивээгдсээр байгаа билээ. Халлелуяа!

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин